



2020 оны 10 дугаар сарын 07
№37 /1139/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Монгол Улс
Олон улсын
гэрээ**

**Монгол Улсын Их Хурлын
2020 оны намрын ээлжит
чуулганаар хэлэлцэх асуудлын
тухай**

Журам батлах тухай

**“Нийгмийн хамгааллын
тухай Монгол Улс болон Бүгд
Найрамдах Чех Улс
хоорондын хэлэлцээр”**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

433. Хэлэлцээр соёрхон батлах тухай 2089

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

434. Монгол Улсын Их Хурлын 2020 оны
намрын ээлжит чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай Дугаар 25 2090

435. Байнгын хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай Дугаар 27 2098

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

436. Журам батлах тухай Дугаар 120 2099

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

437. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх
заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай
хуулийн зарим заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 06 2103

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

438. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон
Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” 2113

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хооронд 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2021 оны хөгжлийн төлөвлөгөө;

2/Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд;

3/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

5/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

7/Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

8/Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

9/Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



10/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/Төрийн нийтийн өмчийн тухай хуулийн төсөл;

12/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот компанийн тухай хуулийн төсөл;

13/Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн төсөл;

14/Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

15/Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

16/Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл;

17/Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл;

20/Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

22/Шүүх байгуулах тухай болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

23/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

24/Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

25/Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

26/Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



27/“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

28/Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төсөл;

29/Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

30/Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
31/Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

32/Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

33/Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл;

34/Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

35/Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл;
36/Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

37/Олон улсын эрүүгийн шүүхийн дархан эрх, эрх ямбын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

38/Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

39/Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

40/“Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Монгол Улсын Консулын газар нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

41/“Хилийн чанадад ажиллах томилолтын хугацаа нь дууссан Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

42/Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

43/Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

44/Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

45/Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

46/Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

47/Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

48/Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

49/Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

50/Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

51/Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл;

52/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

53/Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

54/Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

55/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

56/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

57/Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



58/Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

59/Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

60/Төрийн зарим үйлчилгээг ажлын байртай нь хувийн салбарт шилжүүлэх тухай хуулийн төсөл;

61/Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

62/Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

63/Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

64/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

65/Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

66/Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

67/Генетик нөөцийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

68/Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

69/Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

70/Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

71/Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

72/“Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

73/Музейн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

74/Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төсөл;

75/Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

76/“Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

77/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

78/Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төсөл;

79/Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

80/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

81/“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

82/Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

83/Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

84/Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

85/Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

86/Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;



87/Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

88/Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

89/Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

90/Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

91/Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд;

92/Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

93/Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

94/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

95/Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

96/Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

97/“Үндсэн хуулийн цэцийн гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Төрийн зарим байгууллагын албан тушаалтны ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

98/“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

99/Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

100/Хоол, хүнс шим тэжээлийн боловсролын тухай хуулийн төсөл;

101/“Төр, иргэний нийгмийн түншлэлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

102/Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

103/Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

104/Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

105/Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

106/Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

107/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

108/Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

109/Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл;

110/Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

111/Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



112/“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.“Ковид-19” цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг тухай бүр хэлэлцсүгэй.

3.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

4.Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 1-ний өдөр

Дугаар 120

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2020 оны 120 дугаар
тогтоолын хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “Соёл, урлагийг дэмжих сан” (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сан нь үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13.3-т заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

2.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг байгуулна.



2.3. Ажлын хэсэг нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага, соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.4. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёл, урлагийн бодлогын зохицуулалтын нэгж сангийн үйл ажиллагааг дараах чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ:

2.4.1. тухайн жилд шалгаруулах төсөл, арга хэмжээний төрөл, сэдэв, хувь хэмжээг тодорхойлох;

2.4.2. төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зарлах, саналыг хүлээн авах;

2.4.3. Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13.3-т нийцсэн арга хэмжээний саналыг танилцуулах;

2.4.4. энэ журмын 3.7-д заасан шийдвэрийн дагуу төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулан ажиллах, гүйцэтгэлийг хангуулах;

2.4.5. соёл, урлагийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үр дүнг тооцох, эдгээртэй холбогдсон мэдээ, тайлан гаргах;

2.4.6. шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн дүгнэлт гаргуулах;

2.4.7. сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлж авсан төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу олон нийтэд мэдээлэх, тогтмол шинэчлэх.

Гурав. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах

3.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүлээн авах хугацаанаас нэг сараас багагүй хугацааны өмнө жил бүрийн I улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахимаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Төслийг хүлээн авахаар зарлагдсанаас бусад хугацаанд төсөл хүлээн авахгүй.

3.2. Сонгон шалгаруулалтад оролцох иргэн, хуулийн этгээдийн төсөл, арга хэмжээний санал нь дараах мэдээллийг агуулсан байна:

3.2.1. төрөөс соёлын талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;



3.2.2.төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, цар хүрээ, ач холбогдол, урьдчилсан үр дүнгийн төсөөллийг гаргасан байх;

3.2.3.төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх туршлагатай байх;

3.2.4.төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын болон санхүүгийн төлөвлөгөө, тооцоолол хийсэн байх;

3.2.5.өмнө нь сангаас санхүүжилт авч байсан бол гэрээний биелэлт, үр дүнгийн талаарх тайланг хавсаргасан байх.

3.3. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёл, урлагийн бодлогын зохицуулалтын нэгж нь энэ журмын 3.1-д заасан хугацаанаас хойш ажлын 10 хоногийн дотор энэ журмын 2.2-т заасан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төсөл, арга хэмжээг хэлэлцүүлнэ.

3.4. Ажлын хэсгийн хурлыг гишүүдийн 75-аас дээш хувь оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд санал, дүгнэлтийг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.5. Ажлын хэсгийн хурлаас гаргах дүгнэлт нь тэмдэглэл хэлбэртэй байна. Тэмдэглэлд ажлын хэсгийн дарга, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Ажлын хэсэг нь сангаас санхүүжүүлж авахаар ирүүлсэн төсөл, арга хэмжээнээс сонгон шалгаруулалт хийж, гаргасан дүгнэлтээ соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

3.7. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.6-д заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.1-д нийцүүлэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргана.

3.8. Энэ журмын 3.7-д заасан шийдвэрийн дагуу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, байгууллагатай байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

3.8.1.төсөл, арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх хугацаа;

3.8.2.санхүүжилтийг олгох хуваарь;

3.8.3.санхүүгийн тайлан ирүүлэх хугацаа.

3.9. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, шалгарсан төсөл, арга хэмжээний үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах зардлыг сангаас санхүүжүүлнэ.



3.10. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

4.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

4.2. Сангийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдож гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй, зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгийг эргэн төлүүлэх арга хэмжээ авна.

4.3. Санхүүжилтийг буцаан шилжүүлэх арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж хэрэгжүүлнэ.

4.4. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

4.5. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд гүйцэтгэсэн ажлын үр дүн, төсвийн зарцуулалтын нэгдсэн тайланг энэ журмын 2.4-т заасан байгууллагад гэрээнд заасан хугацаанд танилцуулна.

4.6. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гарган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Тав. Бусад

5.1. Сангийн хөрөнгөнөөс аливаа татаас, урамшуулал, тусламж олгохыг хориглоно.

5.2. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглан зарцуулахыг хориглоно.

5.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, сонгон шалгаруулах, хяналт тавих журам зөрчсөн холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт,
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Солонго даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Н.Ариунболд, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтад "... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг.", Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... прокурорын дүгнэлтээр ... прокурорын эсэргүүцлээр ...", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "... прокурорын дүгнэлтээр ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.", Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно." гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт прокурорын чиг үүргийг тодорхойлж, прокурорын байгууллагын



тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтоох талаар мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан байна. Тухайлбал, прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүрэгтэй. Харин прокурор нь захиргааны эрх зүйн хүрээнд төрийн гүйцэтгэх эрх мэдлийн буюу төрийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт Үндсэн хуульд байхгүй байна. Гэтэл захиргааны зөрчил буюу иргэн, хуулийн этгээдийн захиргааны хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд “захиргаа”-аас захиргааны шийтгэл оногдуулсан байхад уг шийдвэрийг прокурор үл зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлж байхаар хуульд заасан байгаа нь Үндсэн хуулиар прокурорт олгогдоогүй чиг үүргийг хүлээлгэсэн гэж үзэх үндэслэл болно.

Түүнчлэн төрийн хууль гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд үүссэн захиргааны эрх зүйн харилцаанд оролцох чиг үүргийг прокурорт олгосон нь төрийн эрх мэдэл хуваарилах үндсэн суурь зарчимд нийцэхгүй гэж үзнэ. Хууль гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь босоо удирдлагатай бөгөөд дээд байгууллага нь Засгийн газар юм. “Захиргаа” хууль гүйцэтгэх явцдаа хууль зөрчсөн бол түүний дээд байгууллага, албан тушаалтан нь “захиргаа”-ны анх гаргасан хууль бус шийдвэрийг босоо тогтолцооны дагуу хүчингүй болгоно. Энэ нь төр хууль зөрчсөн бол хууль бус шийдвэр, үйл ажиллагаагаа өөрөө хүчингүй болгох зарчим юм.

Нөгөө талаас “захиргаа”-ны шийдвэр иргэн, хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн бол эрх нь зөрчигдсэн гэж үзэж байгаа иргэн, хуулийн этгээдийн гомдлоор дээд шатны захиргаа, эсхүл эрх бүхий шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгоно. Тодорхой тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг зөв, захиргааны хариуцлага хүлээсэн тухайн этгээд өөрийгөө буруутай гэж үзвэл буюу захиргааны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой ямар нэг гомдол, санал гараагүй бол захиргааны анх гаргасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж, эрх зүйн үр дагавар үүсгэдэг.

Гэтэл захиргаа ба иргэн /хуулийн этгээд/-ий хооронд нэгэнт захиргааны эрх зүй /захиргааны зөрчил/-н харилцаа үүссэн байхад захиргааны шийдвэрийг хянах эрх мэдлийг прокурорт олгож, улмаар прокурор нь уг захиргааны шийдвэр хууль бус гэж дүгнэвэл хүчингүй болгуулахаар шүүхэд гомдол буюу дүгнэлт гаргах болж байгаа нь төрийн эрх мэдэл хуваарилсан Үндсэн хуулийн үзэл санаанд үл нийцэж байгаагаас гадна Үндсэн хуулиар шүүх эрх мэдэлд харьяалуулсан прокурорын чиг үүрэгт үл нийцэж байна.

Шүүх нь ялангуяа захиргааны хэргийн шүүх хуулийг хамгаалах, түүний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих чиг үүрэггүй, харин захиргааны хууль бус үйлдлээс иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны

ашиг сонирхлыг тэдгээрийн гомдол, нэхэмжлэлийн дагуу хамгаалах, энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль хэрэглэдэг эрх мэдэл бүхий байгууллага юм. Тиймээс захиргааны шийдвэр үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүргийг прокурорт олгож, улмаар прокурор нь захиргааны хууль бус үйлдлийг зөвтгүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд хандах болж байгаа нь иргэний шүүхэд гомдол мэдүүлэх эрхийг зөрчсөн, шүүх эрх мэдлийг өөрт хамааралгүй /хууль хамгаалах/ асуудалд оролцоход чиглүүлж байгаа нь шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх зарчимтай нийцэхгүй гэж үзэх үндэслэл болно.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “3.1.4.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хяналт, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;” нь Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэж, 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан харилцааг тухайлсан хуулиар, бусад захиргааны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж тус тус хуульчилсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт прокурор нь эрх бүхий албан тушаалтнаас зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэр нь хуульд нийцээгүй гэж үзвэл шүүхэд дүгнэлт гаргаж, анхан шатны журмаар хэлэлцүүлэх, улмаар анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл эсэргүүцэл гаргахаар заасан. Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг улсын байцаагчийн эрх бүхий төрийн захиргааны албан тушаалтан хэрэгжүүлдэг боловч онцлог бүхий тусгай журмаар хэрэгжүүлж /Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль/, эцэст нь зөрчил үйлдсэн этгээд буюу хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах эсэх шийдвэр гаргадаг. Өөрөөр хэлбэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа биш харин хууль зөрчсөн этгээдийг олж тогтоох, зохих хариуцлагыг оногдуулах, учирсан хор хохирлыг арилгахад чиглэдэг.

Иймд зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл хүлээлгэхтэй холбоотой маргааныг захиргааны байгууллага босоо тогтолцооныхоо дагуу эцэслэн шийдвэрлэх бус Үндсэн хуульд заасан гэм буруутай эсэхийг шүүх эцэслэн тогтоох зарчмын дагуу эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн талаарх гомдлыг шүүх хянан шийдвэрлэхээр хуульчилсан.



Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, прокурор эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавина гэж тусгайлан зааж өгөөгүй ба шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэсэн чиг үүргийг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцоно гэж ойлгоно.

Прокурор хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Прокурорын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлтийн, эрүүгийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавих гэсэн 2 хэлбэрээр хэрэгжүүлэн ажилладаг ...

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар прокурорын шүүхэд “дүгнэлт, эсэргүүцэл” гаргах эрх нь эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулахтай холбоотой гаргасан шийдвэрийг прокурор шүүхээс өмнө заавал хянаж үзэх зохицуулалт биш, харин зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэгч нэг субъект болохын хувьд тухайн шийдвэрийн улмаас оролцогчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтны шийдвэртэй холбоотой гомдлыг шүүхэд гаргаж болохыг зөвшөөрсөн зохицуулалт юм. Түүнчлэн зөрчлийн хэрэг бүртгэлт гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг ойлгоно.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа нь хууль, эрх зүйн онолын тодорхой мэдлэг, ажлын дадлага туршлага, ур чадвар шаардсан, нөгөө талаас хүн, хуулийн этгээдэд чиглэсэн, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөнддөг нарийн, төвөгтэй ажиллагаа юм. Энэ ажиллагааг явуулах үед эрх бүхий албан тушаалтны зүгээс тухайн хүн, хуулийн этгээд зөрчлийн субъект болох эсэх, түүний үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй эсэх, шийтгэлээс чөлөөлөх үндэслэл, шийтгэл оногдуулахгүй байх нөхцөл байдал бий болсон эсэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол байгаа эсэх, харьяалан шалгах зөрчил мөн эсэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад оролцогчийн эрхийг хэрхэн хангаж ажиллах, зөрчил шалгах тодорхой ажиллагааг ямар үндэслэлээр, хэрхэн яаж явуулах, хүн, хуулийн этгээдэд ямар тохиолдолд шийтгэл оногдуулж болох зэрэг олон асуудлыг хуулийн мэргэжлийн ойлголт, мэдлэг, ур чадварт тулгуурлан шийдвэрлэх шаардлага алхам тутамд гардаг.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий 28 албан тушаалтан /шүүгч, цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас

бусад/-ы дийлэнх нь хуульч мэргэжлийн албан тушаалтнууд биш бөгөөд тухайн салбарын мэргэшсэн албан хаагч байдаг.

Иймд дээрх эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх, холбогдох хуулийг зөв хэрэглэж байгаа эсэхэд прокурор мэргэшсэн хуульчийн хувьд хяналт тавих шаардлагатай ба эрх бүхий албан тушаалтны зүгээс зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад хүний халдашгүй байх, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн тодорхой ажиллагаануудыг явуулдаг. Тухайлбал, зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгө битүүмжлэх, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, шинжилгээ хийлгэх, хүнийг саатуулах, үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох, Монгол Улсын хилээр гарах эрхийг нь түдгэлзүүлэх зэрэг ажиллагаанд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах зорилгоор прокурор зайлшгүй хяналт тавих шаардлагатай юм.

Түүнчлэн энэхүү зохицуулалт нь оролцогчийн буюу зөрчлийн хохирогч, холбогдогчийн гомдол гаргах эрхийг хязгаарлаагүй /оролцогч өөр, өөр шүүхэд гомдол гаргах эрхтэй/ бөгөөд Прокурорын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан “Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээ авна.” гэсэн зарчмыг хэрэгжүүлэх хяналтын нэг хэлбэр тул Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заасныг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна.

Хууль дээдлэх зарчим нь Үндсэн хуульд ердийн хууль нийцэж байх, ердийн хуульд бусад эрх зүйн актууд нийцэж байх, өөрөөр хэлбэл, дээд эрэмбийн эрх зүйн актыг доод эрэмбийн эрх зүйн акт зөрчиж болохгүй гэсэн агуулгыг илэрхийлж байдаг. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах ...”, 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.”, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд захиргааны акт илт хууль бус байх, 49 дүгээр зүйлд захиргааны актыг хүчингүй болгох зохицуулалтыг тус тус хуульчилсан. Иргэн Н.Ариунболд тусдаа зохицуулалт бүхий ойлголтыг нэгтгэн буруу дүгнэлт хийж, “захиргааны шийдвэрийг хянах



эрхийг прокурорт олгож ... байгаа нь төрийн эрх мэдэл хуваарилсан Үндсэн хуулийн үзэл санаанд үл нийцэж байна” гэж үзсэн нь үндэслэлгүй юм.

Төрийн байгууллагууд хууль тогтоомжоор олгосон чиг үүргийн хүрээнд хяналт шалгалт явуулахад прокурор хяналт тавихгүй, харин хяналт шалгалтын явцад зөрчил илэрсэн үеэс зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тухайн зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчлийн тухай хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс прокурор хяналт тавьдаг. Өөрөөр хэлбэл, зөрчлийн хэрэг бүртгэлтийг хуульч биш этгээд хэрэгжүүлж байгаа учраас хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдаж, эрхийг нь хязгаарлах, хууль зөрчиж нотлох баримт цуглуулах, түүнд үндэслэж шийтгэл оногдуулах зэргээс урьдчилан сэргийлэх үүднээс хөндлөнгийн хяналтыг прокурор тавьж байгаагаараа онцлог юм. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргаж буй прокурорын дүгнэлт, эсэргүүцэл нь эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийтгэл оногдуулсан шийдвэр нь хууль зөрчсөн бол хүчингүй болгох, өөрчлүүлэх, эсхүл илтэд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн байхад үндэслэлгүй хэрэгсэхгүй болгосон бол прокурорын хяналтын явцад илрүүлж хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Харин захиргааны байгууллагаас захиргааны шийдвэр гаргах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуулиар зохицуулдаг. Тухайлбал, энэ хуулиар захиргааны актын нэг гол хэв шинж болох захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагаа нь /Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт зааснаар/ хориглосон, зөвшөөрсөн, журамласан, тогтоосон, эсхүл татгалзсан үйлдэл, эс үйлдэхүй байдаг бол зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэр нь зөрчлийг шалгасны үндсэн дээр хариуцлага хүлээлгэх, эсхүл чөлөөлөх, эсхүл зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол хэрэгсэхгүй болгодоороо ялгаатай юм.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэхэд чиглэгдэх бөгөөд энэхүү ажиллагаанд прокурор хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хяналт тавьж, шийтгэл оногдуулсантай холбоотой гомдлыг шүүх эцэслэн шийдвэрлэхээр хуульчилсан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар улсын байцаагч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тус хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах бөгөөд бүхий л нөхцөлд оролцогчийн буюу хохирогч, холбогдогчийн эрхийг хангах үүрэгтэй.

Ийнхүү улсын байцаагчийн хэрэгжүүлэх зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах эсэх болон хяналт шалгалттай холбоотой шийдвэр гаргах ажиллагаа нь зорилгоос гадна шийдвэр гаргах процесс ажиллагааны

үндэслэл, журмын хувьд эрс ялгаатай онцлогийг нь харгалзан хууль зүйн ялгаатай зохицуулалтыг хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заасныг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна.” гэсэн байна.

Гурав. Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1.Улсын Их Хурлаас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг гэмт хэргээс зааглан тогтоож, мөн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ.” гэж тодорхойлсон бөгөөд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулахтай холбоотой харилцааг тусгай хуулиар буюу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар хуульчилсан. Өөрөөр хэлбэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зорилго, хэрэгжүүлэх үндэслэл, журмын хувьд өөр хоорондоо эрс ялгаатай боловч хэрэгжүүлэгч байгууллага нь нэг гэдэг үндэслэлээр адилтган зөвхөн байгууллагын дотоод хяналтын хүрээнд хэрэгжүүлж, шийдвэр гаргаж ирсэн байдлыг өөрчлөх зорилгоор хууль тогтоогч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад ““зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг;” гэж, мөн зүйлийн 1.2 дахь заалтад ““зөрчлийн хэрэг бүртгэлт” гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах энэ хуульд заасан ажиллагааг;” ойлгоно гэж тус тус тодорхойлсон бөгөөд мөн хуулийн 2.2 дугаар зүйлээр зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих прокурорын эрх хэмжээг хуульчилж өгсөн байна. Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, түүнд шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор хуульд заасны дагуу холбогдох нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх замаар зөрчлийг нотлоход чиглэгддэг бөгөөд энэ ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг тодорхой хүрээнд хязгаарлах шаардлага тулгардаг тул хөндлөнгийн буюу прокурорын хяналт зайлшгүй юм.

Иймд прокурор нь захиргааны байгууллагын бүхий л үйл ажиллагаанд бус зөвхөн зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт



тавьж байгаа бөгөөд энэхүү хяналт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдаж эрхийг нь хязгаарлах, хууль зөрчиж нотлох баримт цуглуулах, түүнд үндэслэж шийтгэл оногдуулах зэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Түүнчлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үүсэх аливаа харилцааг Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд үүсэх харилцаанаас ялгаатай байдлаар зохицуулах шаардлагыг харгалзан, Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хяналт, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;” нь тус хуулийн үйлчлэлд хамаарахгүй байхаар заажээ.

Ийнхүү зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан “Захиргааны байгууллага” мөн боловч онцлог чиг үүрэгтэй болохын хувьд хуульд заасан тусгай журмаар буюу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар ажиллах үүрэгтэй. Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих прокурорын чиг үүргийг зөвхөн гэмт хэргийг шалган тогтоох ажиллагаанд хамааралтай гэж үзэх үндэслэлгүй юм.

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гэмт хэрэг шалгах ажиллагааны нэгэн адил тодорхой хүрээнд хүний эрхийг хөндөх, хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэдэг боловч гэмт хэргийг цагдаагийн байгууллага, харин зөрчлийг захиргааны байгууллага шалгадаг гэдэг утгаар прокурорын хяналтаас гадуур хэрэгжүүлнэ гэдэг нь Үндсэн хуулиар тунхагласан “хүн бүр, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, халдашгүй, чөлөөтэй байх” хүний эрхийг ноцтой зөрчихөд хүргэнэ.

Иймд Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих гэсэн прокурорын чиг үүрэгт “зөрчлийн хэрэг бүртгэх” ажиллагааг хамруулан, Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас 2017 онд Прокурорын тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлд “Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт”, 12 дугаар зүйлд “Зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих прокурорын бүрэн эрх”, 13 дугаар зүйлд “Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналтын арга хэлбэр”, 17 дугаар зүйлд “Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох”, 18 дугаар зүйлд “Зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох” гэсэн зохицуулалтуудыг тус тус хуульчилж өгсөн.

2.Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Захиргааны үйл ажиллагааны хэлбэрийг хуульд өөрөөр заасан тохиолдолд захиргааны байгууллага тухайн хуульд заасны дагуу хэрэглэнэ.” гэж заажээ. Энэ нь эрх бүхий албан тушаалтнаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, шийтгэлээс чөлөөлөх шийдвэр нь Захиргааны ерөнхий хуульд заасан “захиргааны акт”-аас ялгаатай болохыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, эрх бүхий албан тушаалтан нь шийтгэл оногдуулах шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх болон тус шийдвэрт гомдол гаргах, гаргасан гомдлыг шийдвэрлэх ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан нийтлэг журмаар бус Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаад, зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох, шийтгэл оногдуулах, шийтгэлээс чөлөөлөгдөх гэсэн 3 шийдвэрийн аль нэгийг бие даан гаргадаг. Эдгээр шийдвэрийг гаргах нь зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгах ажиллагааны нэг хэсэг тул прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгэгддэг бөгөөд эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх эрх хэмжээг прокурор хэрэгжүүлдэггүй.

Харин прокурор нь зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах чиг үүргийн хүрээнд зөрчлийн хэрэг бүртгэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж дуусгасан эсэхийг хянах явцдаа эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэр хуульд нийцээгүй, хүний эрхийг зөрчсөн гэж үзвэл хянуулахаар шүүхэд дүгнэлт /гомдол/ бичдэг бөгөөд прокурорын энэхүү дүгнэлт нь хэргийн бусад оролцогчийн буюу хохирогч, холбогдогчийн гомдлын нэгэн адил эрх зүйн хүчин чадалтай. Нөгөө талаас прокурор шүүхэд дүгнэлт бичиж байгаа нь тухайн асуудлаар зөрчлийн хохирогч, эсхүл холбогдогчийн шүүхэд хүсэлт, гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлахгүй. ...” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж, уг хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг ойлгохоор заажээ. Мөн уг хуулийн 2.2 дугаар зүйлд зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих прокурорын бүрэн эрхийг хуульчилж, холбогдох зүйл, заалтад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох чиг үүргийг нь тодорхойлсон байна. Түүнчлэн Прокурорын тухай хуулийн



31 дүгээр зүйлд прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрт прокурорын дүгнэлт, прокурорын эсэргүүцэл хамаарахаар хуульчилжээ.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон прокурорын чиг үүргийн хүрээнд, хуулиар тодорхойлсон бүрэн эрхтэй нь уялдуулан прокурорын дүгнэлт, эсэргүүцэл гаргах талаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт зохицуулсан нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин долдугаар зүйлийн 1, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгээр тодорхойлсон Засгийн газрын болон шүүх, прокурорын бүрэн эрхийг хөндсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн түвшинд эрх хэмжээг нь тусгайлан заасан шүүх эрх мэдлийн институт болохын хувьд прокурорын байгууллагын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, үндсэн хуульд ёсыг хангахад чиглэгдэх бөгөөд шүүх эрх мэдлийн хүрээнд тодорхойлсон хэрэг бүртгэлтэд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох прокурорын чиг үүрэг, түүнээс урган гарч байгаа процессын бүрэн эрхийг явцууруулан тайлбарлах боломжгүй юм.

2.Прокурорын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан Прокурорын тухай хууль нь Үндсэн хуульд нэрлэн заасан органик хуулийн хувьд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай зэрэг процессын хуулиас дээд эрэмбийн хууль бөгөөд Прокурорын тухай хуулийн холбогдох зохицуулалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар иргэнээс мэдээлэл гаргаагүй байгааг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтад "... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг.", Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... прокурорын

дүгнэлтээр ... прокурорын эсэргүүцлээр ...”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... прокурорын дүгнэлтээр ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ш.СОЛОНГО

ГИШҮҮД

Д.СОЛОНГО

Г.ТУУЛХҮҮ

Ц.НАНЗАДДОРЖ

Г.БАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ

МОНГОЛ УЛС

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС

ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс (цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх) хоёр улсын нийгмийн хамгааллын салбар дахь харилцааг зохицуулах зорилгоор дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл
Нэр томьёо

1. Энэхүү хэлэлцээрт:

- (a) “хууль тогтоомж” гэж энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийг ойлгоно;
- (b) “эрх бүхий этгээд” гэж энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжоор зохицуулсан асуудлыг эрхлэх яам, эсхүл холбогдох бусад байгууллагыг ойлгоно;
- (c) “эрх бүхий байгууллага” гэж
Монгол Улсын хувьд: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар,
Бүгд Найрамдах Чех Улсын хувьд: Чехийн Нийгмийн Хамгааллын захиргааг ойлгоно;
- (d) “даатгуулсан хугацаа” гэж Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон хууль тогтоомжоор түүнтэй адилтгасан бусад хугацааг ойлгоно;
- (e) “тэтгэвэр” гэж энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн дагуу олгох тэтгэвэр болон бусад мөнгөн олговрыг ойлгоно.

2. Энэхүү зүйлд тодорхойлоогүй аливаа нэр томьёог тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

2 дугаар зүйл
Хамрах хүрээ

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах хууль тогтоомж хамаарна:

- (a) Монгол Улсын тухайд:
 - (i) Тэтгэврийн даатгалын сан болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн;
 - (ii) Нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргийн;
- (b) Бүгд Найрамдах Чех Улсын тухайд:
 - (iii) Тэтгэврийн даатгалаас олгох тэтгэврийн;
 - (iv) Нийгмийн даатгалын шимтгэл болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх үүргийн тухай.

2. Энэхүү хэлэлцээр нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулгад нэгэн адил хамаарна.



3.Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээд нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээдэд Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн хамрах хүрээ өргөжин тэтгэвэр авагчийн шинэ ангилал бий болсон тухай болон уг шинэчилсэн хууль тогтоомж энэхүү хэлэлцээрт хамаарахгүй болохыг хууль хэвлэн нийтлэгдсэнээс хойш 3 сарын дотор бичгээр мэдэгдээгүй бол тухайн хуулийн өөрчлөлт энэхүү хэлэлцээрт хамаарна.

3 дугаар зүйл Хамаарах этгээд

Энэхүү хэлэлцээрт Хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжид хамаарч байгаа, хамаарч байсан этгээд болон түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд хамаарна.

4 дүгээр зүйл Эрх тэгш байдал

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж нь энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан этгээдэд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын иргэний нэгэн адил эрх тэгш үйлчилнэ.

5 дугаар зүйл Тэтгэвэр шилжүүлэх

1.Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тогтоогдсон тэтгэврийг тухайн тэтгэвэр авагч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суудаг, байрладаг гэдэг үндэслэлээр бууруулж, өөрчилж, түр зогсоож, буцаан авч болохгүй бөгөөд тэтгэврийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт олгоно.

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрх нь үүссэн Хэлэлцэн тохиролцогч талуудын нутаг дэвсгэрээс гадна оршин сууж буй Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэний тэтгэврийг Хэлэлцэн тохиролцогч талын нутаг дэвсгэрээс гадна оршин сууж буй Хэлэлцэн тохиролцогч эхний талын иргэний нэгэн адил нөхцөлөөр олгоно.

6 дугаар зүйл Үйл явдлыг адилтгаж үзэх

1.Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт тэтгэвэр авах эрх, тэтгэврийг түдгэлзүүлэх, тэтгэврийн хэмжээг бууруулах эрх зүйн үр дагавар бүхий үйл явдал тохиолдвол түүнийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт болсон мэтээр адилтгаж үзнэ.



2.Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээд зарим тэтгэвэр авагчийн эрх ашгийн үүднээс энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн үйлчлэлийг хязгаарлаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ **Даатгалын тухай заалт**

7 дугаар зүйл **Ерөнхий зүйл**

1.Энэхүү бүлэгт өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохиролцогч талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй этгээд тухайн ажлынхаа хувьд зөвхөн тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

2.Энэхүү зүйлийн 1 дэх хэсэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид мөн адил хамаарна.

8 дугаар зүйл **Томилолтоор ажиллагчид**

1.Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй ажил олгогчоос хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт 5-аас илүүгүй жилийн хугацаагаар ажиллахаар томилогдсон ажилтанд Хэлэлцэн тохиролцогч эхний талын албан журмын даатгалын тухай хууль тогтоомж тухайн талын нутаг дэвсгэрт ажиллаж буй мэтээр үйлчилнэ. Энэхүү зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор ажилтныг илгээсэн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжоор ажил олгогч болон түүний салбар нэгжийг нэг ижил ажил олгогч хэмээн үзнэ.

2.Энэхүү зүйлийн 1 дэх хэсэг нь Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт хувиараа хөдөлмөр эрхлэгч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт түр хугацаагаар хувиараа хөдөлмөр эрхэлж буй тохиолдолд мөн адил үйлчилнэ.

9 дүгээр зүйл **Олон улсын тээвэр болон хөлөг онгоцон дээр ажиллагчид**

1.Хэлэлцэн тохиролцогч хоёр талын нутаг дэвсгэрт олон улсын тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг тээврийн компанид ажилладаг этгээд нь тухайн компанийн бүртгэлтэй албан газар байрлаж буй Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдөнө.

2.Хөлөг онгоц дээр ажилладаг этгээд нь тухайн хөлөг онгоц далбааг нь мандуулсан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг мөрдөнө.



10 дугаар зүйл
Дипломат төлөөлөгчийн газрын ажилтан
болон төрийн албан хаагчид

1.Энэхүү хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийн заалтад нөлөөлөхгүй.

2.Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт хамаарахгүй Хэлэлцэн тохирогч нэг талын хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагч, эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохиролцогч эхний талын хууль тогтоомжийг мөрдөнө.

11 дүгээр зүйл
Онцгой тохиолдол

Ажилтан болон ажил олгогчийн хамтын хүсэлт, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүсэлтийн дагуу Хэлэлцэн тохиролцогч хоёр талын эрх бүхий этгээд, эсхүл тэдний томилсон эрх бүхий байгууллага Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид хамаарах хувь хүн болон бүлэг хүмүүсийг энэхүү бүлгийн зүйл заалтын үйлчлэлд хамааруулахгүйгээр тохиролцож болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
Тэтгэврийн талаарх заалтууд

12 дугаар зүйл
Даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцох

1.Хэлэлцэн тохиролцогч хоёр талд хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн бол Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн эрх бүхий байгууллага нь хуулийн дагуу тэтгэвэр тогтоох эрхийг тодорхойлохдоо нөгөө Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааг эхний Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацаатай давхцаагүй тохиолдолд нэгтгэн тооцно.

2.Хэлэлцэн тохиролцогч талын гуравдагч улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээр шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцоход нөлөөлж байвал хоёр тал нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцохдоо гуравдагч улстай байгуулсан хэлэлцээрээс үүсэх хариуцлагыг харгалзан үзнэ.



13 дугаар зүйл

Тэтгэврийн хэмжээг тогтоох

1.Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжоор Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцолгүйгээр тэтгэвэр авах эрх үүсч байвал Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага тэтгэврийг дараах байдлаар бодож тогтооно. Үүнд:

- (a) Зөвхөн өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд үндэслэх бөгөөд
- (b) Тэтгэврийн хэмжээ нь (a) заалтын дагуу хийсэн тооцооны дүнтэй тэнцүү, эсхүл түүнээс бага биш бол 2 дахь хэсэгт зааснаар.

2.Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгох эрх нь зөвхөн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын, эсхүл 12 дугаар зүйлд заасны дагуу гуравдагч талын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг харгалзаж үүсэхээр бол Хэлэлцэн тохиролцогч эхний талын эрх бүхий байгууллага:

- (a) Даатгалын шимтгэл төлсөн бүх хугацааг өөрийн орны хууль тогтоомжийн дагуу төлсөн мэтээр үзэж тэтгэврийн онолын хэмжээг бодож тооцно
- (b) (a) заалтын дагуу тооцсон тэтгэврийн онолын хэмжээг тогтоосны дараа олговол зохих тэтгэврийн хэмжээг тооцоходоо өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэж тооцсон нийт шимтгэл төлсөн хугацаанд харьцуулан ногдох тэтгэврийн хэмжээг тогтооно.

Эрх бүхий байгууллага нь тэтгэвэр бодоход баримтлах цалин, орлогыг тодорхойлохдоо тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн цалин, орлогыг харгалзан үзнэ. Тэтгэврийн онолын хэмжээг тогтооход баримтлах цалин, орлогыг өөрийн орны хууль тогтоомжийн дагуу индексжүүлж дунджийг тооцно.

3.Даатгуулагч 1 ба 2 дахь хэсэгт заасны дагуу бодож тооцсон тэтгэврийн аль их хэмжээтэйг нь авах эрхтэй.

14 дүгээр зүйл

12 сараас доош шимтгэл төлсөн хугацаа

Хэрэв Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжоор шимтгэл төлсөн хугацаа нь 12 сараас бага бөгөөд тэтгэвэр авах эрх

үүсэхээргүй бол тухайн Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага тэтгэвэр олгохгүй. Энэ хугацааг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацаа мэтээр харгалзан үзэж тооцно.

15 дугаар зүйл

Бүгд Найрамдах Чех Улсад хамаарах тусгай зүйл

1.18 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон бөгөөд Бүгд Найрамдах Чех Улсын даатгалын тогтолцоонд шаардлагатай хугацааны турш хамрагдаагүй этгээд нь зөвхөн Бүгд Найрамдах Чех Улсын байнгын оршин суугч бол тахир дутуугийн бүрэн тэтгэвэр авах эрхтэй.

2.Энэхүү хэлэлцээрийн 12 дугаар зүйлийг үл харгалзан, даатгуулсан хугацааг орлуулан тооцохдоо Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжид заасан даатгалын шимтгэл төлөх доод хугацааны нөхцөл шаардлагыг хангахын тулд зөвхөн Бүгд Найрамдах Чех Улсад даатгуулсан хугацааг харгалзан үзнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл

Удирдлагын тохиролцоо

1.Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдүүд нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгасан Удирдлагын тохиролцоог байгуулна.

2.Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн харилцагч байгууллагыг Удирдлагын тохиролцоонд тусгаж өгнө.

17 дугаар зүйл

Мэдээлэл солилцох, харилцан туслах

1.Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллагууд болон харилцагч байгууллагууд нь хууль тогтоомжийн дагуу өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл солилцож, харилцан туслалцаа үзүүлнэ.

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас явуулсан баримт бичгийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ эрүүл мэндийн байдлыг үнэлэх буюу тахир дутуугийн зэрэг тогтоох тухайд зөвхөн тэтгэвэр олгох үүрэг бүхий Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий байгууллага дангаараа шийдвэр гаргах бөгөөд ингэхдээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагын гаргасан тодорхойлолт, эмнэлгийн дүгнэлтийг харгалзан үзэж болно.



3.Хэлэлцэн тохиролцогч нэг талын нутаг дэвсгэрт оршин суугаа этгээдэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу шаардагдах эмнэлгийн үзлэгийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байгаа эмч, эмнэлгийн байгууллага, эсхүл дээрх этгээдийн оршин суугаа газрын байгууллага гүйцэтгэнэ.

4.Энэхүү зүйлд заасан туслалцааг харилцан төлбөргүйгээр үзүүлнэ.

18 дугаар зүйл **Солилцсон мэдээллийн нууцлал**

Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нэг талд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын дамжуулж буй хувь хүний тухай мэдээллийг зөвхөн энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана. Хэлэлцэн тохиролцогч нэг талын хүлээн авсан мэдээлэл нь хувь хүний нууц болон хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах тухай Хэлэлцэн тохиролцогч тухайн талын үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдана.

19 дүгээр зүйл **Хураамжаас чөлөөлөх, баримт бичгийг баталгаажуулах**

1.Хэлэлцэн тохиролцогч талын эрх бүхий этгээдэд буюу эрх бүхий байгууллагад явуулсан аливаа баримт бичгийг төлбөр, хураамж, түүний дотор консулын болон захиргааны хураамжаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөхөөр Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжид заасан бол энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий этгээдэд эсхүл эрх бүхий байгууллагад явуулсан ижил төрлийн баримт бичгийг төлбөр, хураамжаас мөн адил бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлнө.

2.Энэхүү хэлэлцээрийн зорилгоор ашиглагдах баримт бичиг, гэрчилгээг дипломат буюу консулын эрх бүхий байгууллагаар баталгаажуулах шаардлага тавихгүй.

3.Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллагаас үнэн зөв болохыг тодорхойлсон баримт бичгийн хуулбарыг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллага дахин баталгаажуулахгүйгээр үнэн, зөв хэмээн хүлээн авна.

20 дугаар зүйл **Харилцах хэл, харилцаа**

1.Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын өргөдөл, эсхүл баримт бичгийг нөгөө талын албан ёсны хэлээр, эсхүл англи хэлээр үйлдсэн гэсэн шалтгаанаар хүлээн авахаас татгалзаж болохгүй.

2.Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээд, эрх бүхий байгууллага, эсхүл харилцагч байгууллагууд нь өөр хоорондоо, мөн түүнчлэн аливаа этгээдтэй энэхүү хэлэлцээр болон энэхүү хэлэлцээрт хамаарах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх шаардлага гарсан тохиолдолд тухайн этгээд хаана оршин сууж байгаагаас үл хамааран хэдийд ч шууд харилцаж болно. Талууд Хэлэлцэн тохиролцогч аль ч талын албан ёсны хэлээр, эсхүл англи хэлээр харилцаж болно.

21 дүгээр зүйл **Тэтгэвэр тогтоолгох өргөдөл**

1.Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллагад тэтгэвэр тогтоолгохоор гаргасан өргөдлийг дараах нөхцөлд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу гаргасан өргөдөл гэж үзнэ.

- (a) Өргөдөл гаргагч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу авч үзэхийг хүссэн;
- (b) Өргөдөл гаргагч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжийн дагуу шимтгэл төлсөн хугацааны талаар мэдээлэл өгсөн;

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллагад өргөдөл гаргагч нь гаргасан өргөдлөө Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох өргөдөл гэж тооцуулахгүй байх хүсэлтийг, эсхүл Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын хууль тогтоомжид нийцүүлэн өргөдлийг өөр өдрөөс эхлэн авч үзэхээр тус тус хүсэлт гаргаж болно.

22 дугаар зүйл **Давж заалдах**

Хэлэлцэн тохиролцогч нэг талын эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг давж заалдан, Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад бичгээр өргөдөл гаргаж болно. Давж заалдах өргөдлийг тухайн шийдвэрийг гаргасан Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл **Нэхэмжлэл, мэдэгдэл, давж заалдах өргөдлийг дамжуулах**

1.Энэхүү хэлэлцээрийн 21, 22 дугаар зүйлийг хэрэглэх аливаа тохиолдолд нэхэмжлэл, мэдэгдэл, эсхүл давж заалдах өргөдлийг хүлээн авсан эрх бүхий байгууллага нь хүлээн авсан өдрийг баримт бичигт тэмдэглэж, Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын харилцагч байгууллагад саатуулалгүй хүргүүлнэ.

2.Хэлэлцэн тохиролцогч нэг талын хууль тогтоомжийн дагуу гаргах аливаа өргөдөл, мэдэгдэл, эсхүл нэхэмжлэлийг тухайн Хэлэлцэн



тохиролцогч талын эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд нь гаргах шаардлагатай боловч Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын эрх бүхий байгууллагад мөн хугацаанд нь гаргасан бол тухайн өргөдлийг хугацаандаа гаргасан хүсэлт гэж үзнэ.

24 дүгээр зүйл Тэтгэвэр олгох

1.Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нөгөө талруу тэтгэврийг чөлөөтэй хөрвөх валютаар шилжүүлнэ.

2.Хэлэлцэн тохиролцогч тал нь тухайн Хэлэлцэн тохиролцогч талын нутаг дэвсгэрээс гадна байгаа этгээдэд төлбөр, гуйвуулга буюу мөнгөн сан, санхүүгийн хэрэгслийг шилжүүлэхэд валютын хяналт, хязгаарлалт тавьсан буюу түүнтэй төстэй бусад арга хэмжээ авсан тохиолдолд, тухайн Хэлэлцэн тохиролцогч тал нь төлбөрийг энэхүү хэлэлцээрийн дагуу хийх боломжит арга хэмжээг нэн даруй авна.

25 дугаар зүйл Илүү олгосон төлбөр

Тэтгэвэр авагчид илүү олгосон төлбөрийн асуудлыг Хэлэлцэн тохиролцогч талуудын холбогдох байгууллагууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

26 дугаар зүйл Маргааныг шийдвэрлэх

1.Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарч болох саналын зөрүү, маргааныг Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий этгээдийн тохиролцоогоор шийдвэрлэнэ.

2.Өмнөх заалтын дагуу зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээ хийж шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ Шилжилтийн болон төгсгөлийн зүйл

27 дугаар зүйл Шилжилтийн заалт

1.Энэхүү хэлэлцээр нь хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр авах эрх үүсгэхгүй.

2.Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө даатгалын шимтгэл төлсөн хугацаа, бусад холбогдох үйл явдлыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тэтгэвэр авах эрхийг тодорхойлоход харгалзан үзнэ.



Ингэхдээ, хоёр улсын Засгийн газар хооронд өмнө байгуулсан хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах Чех Улсад 1995 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сурсан, ажилласан хугацааг даатгуулсан хугацаанд оруулан тооцоходоо техник мэргэжлийн дунд сургуульд багшилсан, Монгол Улсад үзүүлсэн хөгжлийн тусламжийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсын ерөнхий боловсролын сургууль, их сургуульд тэтгэлэгтэй сурсан болон Монгол иргэдийг ирээдүйн ажил мэргэжилд нь бэлтгэж, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор Чехословакийн байгууллагуудад түр хугацаагаар ажиллуулсан хугацааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгуулсан хугацаанд тооцно. Харин энэхүү хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн а)-д заасан хугацаа нь Чех Улсад даатгалын шимтгэл төлсөн бусад хугацааг оролцуулан зөвхөн Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр авах эрх үүсгэхээр бол Монголын Улсын хууль тогтоомжийг хэрэглэхгүй.

3.Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн тэтгэвэр авах эрх нь энэ хэлэлцээрийн дагуу үүсэх эрхэд нөлөөлөхгүй.

4.Гагцхүү энэхүү хэлэлцээрийн зохицуулалтаас үүдэн тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт орохоор бол энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө тогтоосон тэтгэврийг өргөдөл гаргаснаар шинэчлэн тогтоож болно.

5.Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Хэлэлцэн тохиролцогч талд томилолтоор ажилласан этгээдийн тухайд энэхүү хэлэлцээрийн 8 дугаар зүйлийг хэрэглэхдээ тэрхүү зүйлд дурдсан ажилласан хугацааг энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцно.

28 дугаар зүйл Цаг хугацааны хязгаар

27 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн хууль тогтоомжид заасан хугацаа хамгийн эртдээ энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлнэ.

29 дүгээр зүйл Соёрхон батлах, хүчин төгөлдөр болох

1.Энэхүү хэлэлцээрийг соёрхон батална.

2.Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардагдах хууль эрх зүйн бүх шаардлагыг хангасан тухайгаа бичгээр мэдэгдсэн сарын дараа сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.



30 дугаар зүйл
Хэлэлцээрийн хүчинтэй хугацаа, дуусгавар болох

1. Энэхүү хэлэлцээр нь хязгааргүй хугацаанд хүчин төгөлдөр байна.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь хэлэлцээрийг дуусгавар болгох тухай Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа бичгээр мэдэгдсэнээр хэлэлцээр дуусгавар болж болно. Хэлэлцээр дуусгавар болох тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нэг тал нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа энэ тухай бичгээр мэдэгдэл хүргүүлсэн жилийн дараагийн хуанлийн жил дуусах хүртэл хугацаанд хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

3. Энэхүү хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд, хэлэлцээрийн дагуу тогтоогдсон тэтгэвэр болон тэтгэврийн эрх нь хэвээр хадгалагдана. Хэлэлцээрийг дуусгавар болох үед шийдвэрлэгдэх шатандаа байгаа эрхийг Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, бүрэн эрх олгогдсоны дагуу энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг 2019 оны 05 сарын 20-ны өдөр Прага хотноо монгол, чех, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

МОНГОЛ УЛСЫН ГАДААД
ХАРИЛЦААНЫ САЙД
ДАМДИНЫ ЦОГТБААТАР

БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХЭРГИЙН
САЙД ЯНА МАЛАЧОВА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003